



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/576

Алтай хот

Орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг хүлээлгэн өгөх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалт, Засгийн газрын 204 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг Нийтлэг үйлчилгээний газарт хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Эрдэнэбат	(Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Б.Балдорж	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Х.Лхагважав	(Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга	Р.Пүрэвдорж	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР